СҮХБААТАР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
STATISTICS DIVISION OF SUKHBAATAR DISTRICT

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

# ИНФОГРАФИК
## 2022/I



2022 ОН ХОТЫН ИРГЭНИЙ ЖИЛ

## ХҮН АМ

Дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар урьдчилсан дүнгээр 39659 өрхийн 147378 суурин хүн ам оршин сууж байна. 2021 оны жилийн эцсийн хүн амын тоо 3-р сарын эхээр эцэслэн гарна.

2022 оны эхний 1 сард 127 хүүхэд шинээр мэндэлж, 1000 хүнд ногдох төрөлт 0.9 болж, өмнөх оны мөн үеийнхээс 0.6 пунктээр буурчээ.

### 1000 ХҮНД НОГДОХ



Төрөлт 0.9 | Нас баралт 0.4

Ердийн цэвэр өсөлт 0.5

Оны эхний 1 сарын байдлаар нас баралт 58 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 12-оор (26.1%) нэмэгдсэн байна.

### ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, *сүүлийн 5 жилийн эхний 1 сард*

0.5 — Хамгийн бага

Хамгийн их — 1.3

Ердийн цэвэр өсөлт: Хүн амын тооны өсөлт, бууралтыг харуулна.

## ТӨРСӨН ХҮҮХЭД



2022 I — 127

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 1 сард 128 эх амаржиж, 127 хүүхэд шинээр мэндэлж, 1 амьгүй төрөлт бүртгэгдсэн байна.

Эх, хүүхдийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 тохиолдлоор буюу 50.0%-иар буурсан зэрэг үзүүлэлттэй байна.

### ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

| | |
|---|---|
| 0-1 хүртэлх насны | 2↓ |
| 1-5 хүртэлх насны | 0 |
| Эхийн эндэгдэл | 0 |

### ЭХИЙН ТӨРӨЛТ

| | |
|---|---|
| Амьгүй төрөлт | 1 |

Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 39.6 хувиар буурчээ. Гэрийн төрөлт болон хяналтгүй төрөлт бүртгэгдээгүй байна.

## ЭРҮҮЛ МЭНД

### НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 2021 I | Халдварт өвчин | 15 | 62 |
| | Цочмог халдварт өвчин | 47 | |
| 2022 I | Халдварт өвчин | 20 | 8796 |
| | Цочмог халдварт өвчин | 8776 | |

2022 оны эхний 1 сард 10.0 мянган хүн тутмын 605 нь цочмог, 1 нь халдварт өвчнөөр өвчилсөн байна.

### ХАЛДВАРТ ӨВЧИН - 20

- Тэмбүү 7 ↑
- Мөөгөнцөр 1 ↑
- Заг хүйтэн 8 ↑
- Сүрьеэ 4
- Трихомониаз 0

### ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН - 8776

- Гар, хөл, амны өвчин 3 ↑
- Салхин цэцэг 8 ↑
- Ковид 8765 ↑

COVID CORONAVIRUS

2022 оны 1 сард коронавирус халдварын 8765 тохиолдол бүртгэгдсэн нь халдварт өвчний өсөлтөд голлон нөлөөлсөөр байна.

## НИЙГМИЙН ХАЛАМЖ



### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

| | 2021 I | 2022 I | |
|---|---|---|---|
| ОРЛОГО, тэрбум төгрөг | 1 125.0 | 150.3 | ↑ |
| ЗАРЦУУЛАЛТ, тэрбум төгрөг | 939.4 | 208.9 | ↓ |
| Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүн | 9 108 | 9 854 | ↑ |

## НИЙГМИЙН ДААТГАЛ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

| | 2021 I | 2022 I | |
|---|---|---|---|
| ОРЛОГО, *тэрбум төгрөг* | 20.0 | 28.9 | ↑ |
| ЗАРЛАГА, *тэрбум төгрөг* | 12.4 | 12.0 | ↓ |

### ОЛГОСОН ТЭТГЭВЭР

| | 2021 I | 2022 I | |
|---|---|---|---|
| Тэтгэвэр авагчийн тоо, *мянган хүн* | 19.9 | 20.6 | ↑ |
| Олгосон тэтгэвэр, *тэрбум төгрөг* | 9.5 | 10.1 | ↑ |

### ОЛГОСОН ТЭТГЭМЖ

| | 2021 I | 2022 I | |
|---|---|---|---|
| Хамрагдсан хүн, *мянган хүн* | 1.7 | 2.4 | ↑ |
| Олгосон тэтгэмж, *тэрбум төгрөг* | 2.9 | 1.9 | ↓ |

## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

**2021 I 355** **2022 I 497** ↑

### БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, *насны ангиллаар, дүнд эзлэх хувиар*, 2022 I

| Насны ангилал | Нийт | Хувь | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|---|
| 15-24 насны | 67 | (13.5%) | 34 | 33 |
| 25-34 насны | 200 | (40.2%) | 102 | 98 |
| 35-44 насны | 141 | (28.4%) | 64 | 77 |
| 45-54 насны | 68 | (13.7%) | 30 | 38 |
| 55-59 насны | 18 | (3.6%) | 14 | 4 |
| 60+ насны | 3 | (0.6%) | 0 | 3 |

Дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо оны эхний 1 сард 497 болж, өмнөх оны мөн үеэс 142-оор (40.0%) өссөн үзүүлэлттэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 1 сард 47 иргэн ажилд зуучлагдан оржээ.

## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

**2021 I** 163

**2022 I** 361 ↑



| 1-р хэлтэс | 2-р хэлтэс |
|---|---|
| (1-9 дүгээр хороо) | (10-20 дугаар хороо) |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг 233 (64.5%) | Бүртгэгдсэн гэмт хэрэг 128 (35.5%) |
| Илрүүлэлт 25.4% | Илрүүлэлт 22.5% |

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 1 сард 1-р хэлтэст 233, 2-р хэлтэст 128, нийт 361 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 198 хэргээр (2.2 дахин) өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт дүүргийн хэмжээнд 26.2 хувьтай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 6.5 пунктээр нэмэгджээ.

## БҮРТГЭГДСЭН ТҮЙМЭР, ҮЕР, УС

### БҮРТГЭГДСЭН ГАЛ ТҮЙМЭР, *төрлөөр*

| | 2021 I | 2022 I |
|---|---|---|
| Обьектын | 16 | 14 ↓ |
| Хогны | - | 1 ↑ |

### БҮРТГЭГДСЭН ҮЕР, УСНЫ ДУУДЛАГА

| | 2021 I | 2022 I |
|---|---|---|
| Үер ус, халианы | 4 | 1 ↓ |

2022 оны 1 сард дүүргийн хэмжээнд объектын гал түймрийн 14, хогны 1, нийт 15 тохиолдол бүртгэгджээ.

Мөн 20-р хорооны Цолмонгийн аманд гадаргын усны халианы 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

### ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, *сая төгрөг*

- Төлөвлөгөө 10 175.2
- Гүйцэтгэл 6 396.0
- Биелэлт 62.9%

2022 оны 1 сард дүүргийн төсөвт 6.4 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 62.9 хувиар биелжээ. Төвлөрсөн орлогын 85.2 хувийг урсгал орлого, 14.8 хувийг төсвийн урсгал санхүүжилтийн орлого эзэлж байна. Урсгал орлогын 97.3 хувийг татварын орлого, 2.7 хувийг татварын бус орлого бүрдүүлж байна. Татварын орлого төлөвлөснөөс 271.0 сая төгрөгөөр давж 105.7%-иар биелжээ.

### ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА, *сая төгрөг*

- Төлөвлөгөө 10 152.6
- Гүйцэтгэл 6 182.1
- Биелэлт 60.9%

Оны эхний 1 сарын байдлаар төсвийн зардал төлөвлөснөөс 4.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ. Төсвийн урсгал зардлын дийлэнх буюу 81.8% нь бусад зардал байна.

## АЖ ҮЙЛДВЭР

**2021 I**
- Нийт үйлдвэрлэл 292.7 *тэрбум төгрөг*
- Нийт борлуулалт 591.7 *тэрбум төгрөг*

**2022 I**
- Нийт үйлдвэрлэл 240.1*↓ *тэрбум төгрөг*
- Нийт борлуулалт 455.1*↓ *тэрбум төгрөг*

### АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, *салбараар*

| | 2021 I | 2022 I |
|---|---|---|
| УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (4.3%↑) | 206.1 *тэрбум төгрөг* | 214.9*↑ *тэрбум төгрөг* |
| БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (70.9%↓) | 86.3 *тэрбум төгрөг* | 25.1*↓ *тэрбум төгрөг* |
| ЦАХИЛГААН, ДУЛААН, ЭРЧИМ ХҮЧ, УСАН ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛ (66.7%↓) | 0.3 *тэрбум төгрөг* | 0.1*↓ *тэрбум төгрөг* |

## ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ



Цэвэрлэсэн зам талбай 436.8 *мян.м2*

Зарцуулсан хөрөнгө 234.1 *сая төгрөг*

### ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ, *байршлаар*, 2022 I

- Орон сууцнаас 3 147.0 тн
- Гэр хорооллоос 2 032.0 тн
- Зуслангаас 824.0 тн

2022 оны 1 сард дүүргийн хэмжээнд 6.0 мянган тонн хог тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 0.3 мянган тонноор буюу 6.1 хувиар өсжээ.

Тээвэрлэсэн хогны 52.4 хувийг орон сууцнаас, 33.9 хувийг гэр хорооллоос, 13.7 хувийг зуслангаас тус тус тээвэрлэжээ. Хог тээвэрлэлтэд нийт 234.1 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 20.7 сая төгрөгөөр (9.7%) өссөн үзүүлэлттэй байна.